



**Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн
захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын
2026 оны 1 дүгээр улирлын шилэн дансны үйл
ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай**

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр баталсан 29/05 дугаар удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын 2026 оны 1 дүгээр улирлын шилэн дансны үйл ажиллагаанд 206 байгууллага нь 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 8351 мэдээлэл байршуулах ёстойгоос 97,6% буюу 8147 мэдээллийг хуулийн хугацаанд, 2,3% буюу 193 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 0,1% буюу 11 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 97,6% гарлаа.



Мэдээлэл хугацаандаа байршуулалтыг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Мэдээлэл байршуулалтыг байгууллагын төрлөөр нь ангилан харуулбал:

Боловсролын салбарын 81 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 3402 мэдээлэл байршуулах ёстойгоос 3348 мэдээллийг хуулийн хугацаанд, 47 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 байгууллага 7 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 98,4 % гарлаа.

Соёлын салбарын 23 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 966 мэдээлэл байршуулах ёстойгоос 951 мэдээллийг хуулийн хугацаанд, 15 мэдээллийг

хугацаа хоцроож байршуулсан байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 98,5% гарлаа.


Эрүүл мэндийн салбарын 21 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 718 мэдээлэл байршуулах ёстойгоос 695 мэдээллийг хуулийн хугацаанд, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 96,8% гарлаа.

Орон нутгийн төсвийн 48 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 2016 мэдээлэл байршуулах ёстойгоос 1973 мэдээллийг хуулийн хугацаанд, 43 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 97,9%.


20 төрийн сан 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 780 мэдээлэл байршуулах ёстойгоос 726 мэдээллийг хуулийн хугацаанд, 51 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 байгууллага 3 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 93,1% гарлаа.

Орон нутгийн өмчит 13 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 469 мэдээлэл байршуулах ёстойгоос 454 мэдээллийг хуулийн хугацаанд, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 байгууллага 1 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 96,8%.

2026 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны улирлын мэдээг хуулийн хугацаанд илгээлт 96,5% буюу 194 байгууллага, хугацаа хоцорч илгээсэн 2% буюу 4 байгууллага, огт илгээгүй 1% 2 байгууллага, хянагдаагүй 0,5% буюу 1 байгууллага байна. Улирлын мэдээ илгээлтэд хамаарахгүй 5 байгууллага байна.



Хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлтийг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:



Улирлын мэдээ илгээлтийг салбар тус бүрээр авч үзвэл:

Боловсролын салбарын 81 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 78 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 1 байгууллага, огт илгээгүй 1 байгууллага, хянагдаагүй 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 96,3%.

Соёлын салбарын 23 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 23 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 100%.

Эрүүл мэндийн салбарын 21 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 17 байгууллага. Улирлын мэдээ илгээлтэд 4 өрхийн эмнэлэг хамаарахгүй. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 100%.

Орон нутгийн төсвийн 48 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 47 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 97,9%.

20 төрийн сангийн улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 19 байгууллага, огт илгээгүй 1 байгууллага байна. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 95%.

Орон нутгийн өмчит 13 байгууллагын улирлын мэдээ илгээлт хугацаандаа мэдээ илгээсэн 10 байгууллага, хугацаа хоцроож илгээсэн 2 байгууллага байна. Улирлын мэдээ илгээлтэд Ахмадын өргөө хамаарахгүй. Эндээс хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 83,3%.

Төсөвт 169 байгууллагын батлагдсан төсөв байршуулалтад хяналт хийхэд эдийн засгийн ангилалын дагуу дэлгэрэнгүй задалж байршуулсан 59,2% буюу 100 байгууллага, эдийн засгийн ангилалын кодоор задлаж байршуулсан 14,2% буюу 24 байгууллага, хөтөлбөр зориулалтын бөөн дүнгээр байршуулсан 11,2% буюу 19 байгууллага, байгууллагын батлагдсан төсөв огт байршуулаагүй 15,4% буюу 26 байгууллага.

Байгууллагуудын батлагдсан төсөв байршуулалтыг харахад эдийн засгийн ангиллын кодоор, хөтөлбөр зориулалтын дүнгээр байршуулсан нь иргэд олон нийтэд нээлттэй бус, ойлгомжгүй, ямар зардалд хэдэн төгрөг батлагдсан байгааг харах боломжгүйгээр байршуулж, зарим байгууллага батлагдсан төсвийг бөөн дүнгээр байршуулсан эвсэл зөвхөн орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа тогтмол зардлыг байршуулж, байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийг огт байршуулаагүй, мөн Арвайхээр сумын 11 дүгээр тусгай цэцэрлэг, Уянга сумын 2 дугаар цэцэрлэг, ИТХурал, ЗДТГазар зэрэг байгууллагууд батлагдсан төсвөө огт байршуулаагүй, оруулах мэдээлэл байхгүй гэсэн сонголтыг сонгож, Хайрхандулаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь байгууллагын батлагдсан төсөв ирээгүй гэж **худал** мэдээлжээ.

Шалгалтын дүгнэлт

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 97,6%, хуулийн хугацаанд улирлын мэдээ илгээлт 96,5%, байгууллагын батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу байршуулалт 59,2%, байгууллагууд батлагдсан төсвөө огт байршуулаагүй, жилийн батлагдсан төсвийг бөөн дүнгээр байршуулдаг, эдийн засгийн ангиллын кодоор болон хөтөлбөр зориулалтын бөөн дүнгээр байршуулсан зэрэг шилэн данс хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл байршуулах, тайлан илгээх, байршуулсан мэдээллийн чанарт гарч байгаа зөрчлүүд нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн хариуцлагагүй байдал, ажилдаа хайнга ханддаг, хугацааг нь тулган мэдээллээ дутуу хагас чанаргүй байршуулдаг, мөн төсвийг эдийн засгийн ангиллын код, хөтөлбөр, зориулалтын бөөн дүнгээр мэдээлэл оруулж байгаа нь төсвийн зарцуулалтын ил тод байдал алдагдана гэж дүгнэлээ.

Иймд байгууллагууд батлагдсан төсвийг хууль, журмын дагуу бүрэн, дэлгэрэнгүй байдлаар байршуулж, мэдээллийн чанар, бүрэн байдлыг сайжруулах шаардлагатай байна.

Байгууллагуудын цаашид анхаарах асуудлууд

1. Байгууллагын удирдлага болон дотоод хяналтын нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлэх, удирдлага хариуцлага тооцон ажиллах;

2. Байгууллагын батлагдсан төсвийг байршуулаагүй байгууллагууд дэлгэрэнгүй эдийн засгийн ангиллын дагуу нөхөн байршуулах;

3. Байгууллагууд улирлын мэдээ тайланг хуулийн хугацаанд илгээх, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж хэвших;

4. Байгууллагын удирдлага болон мэдээлэл байршуулах албан хаагчид шилэн дансанд байршуулж буй мэдээллийн хугацаа хоцролт, үнэн зөв бүрэн байршуулалтад анхаарч ажиллах;

5. Өгсөн үүрэг даалгавар болон зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах;